



**НИЙСЛЭЛИЙН  
СПОРТЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар A/38

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын аварга шалгаруулах  
бүжгийн спортын тэмцээнийг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах бүжгийн спортын тэмцээнийг 2019 оны 06 дүгээр сарын 08-ны өдөр “Наадам спорт комплекс”-т зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.990.000 /нэг сая есөн зуун ерэн мянган/ төгрөгийг Нийслэлийн спортын хорооны биеийн тамирын уралдаан тэмцээний зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спортын хөгжлийн хэлтэс /С.Саранцэцэг/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн спортын хорооны даргын 2019 оны  
*дугаар* сарын *06*-ны өдрийн *А/Б* дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

Улаанбаатар хотын аварга шалгаруулах  
бүжгийн спортын тэмцээний төсөв <sup>7448</sup>

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 1-р байр 10 хүн х 20.000 төг = 200.000 төг 2-р байр 10 хүн х 15.000 төг = 150.000 төг 3-р байр 10 хүн х 10.000 төг = 100.000 төг	450.000
2.	Шүүгчдийн ажлын зардал: /12 хүн х 2 өдөр х 20.000 төг/	480.000
3.	Заалны түрээс	400.000
4.	Өргөмжлөл	60.000
5.	Медаль: 30 ш х 20.000 = 600.000	600.000
<b>Нийт дүн</b>		<b>1.990.000</b>

Нийслэлийн спортын хорооны даргын 2019 оны  
*Зурмыугаар* сарын 06-ны өдрийн *1/3* дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

Улаанбаатар хотын аварга шалгаруулах  
бүжгийн спортын тэмцээний  
шүүгчдийн бүрэлдэхүүн

- |                       |               |
|-----------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч      | О.Саранхүү    |
| 2. Нарийн бичиг шүүгч | А.Алтанцэцэг  |
| 3. Шүүгч              | Э.Анужин      |
| 4. Шүүгч              | Ц.Хонгорзул   |
| 5. Шүүгч              | М.Мөнгөнзаяа  |
| 6. Шүүгч              | А.Алтанцаг    |
| 7. Шүүгч              | Б.Баясгалан   |
| 8. Шүүгч              | А.Алдармаа    |
| 9. Шүүгч              | С.Отгонбаатар |
| 10. Шүүгч             | Б.Батсайхан   |
| 11. Шүүгч             | Ү.Мөнхшүр     |
| 12. Шүүгч             | У.Ундрах      |